

"Бүх нийт боловсроли тавар!"  
Иргэний нийгмийн үндэсний эвсэг



# НАЙЗЫГ МИНЬ СУРГУУЛЬД ОРУУЛ

Бодлогын нөлөөлөлд ашиглах мэдээлэл







# НАЙЗЫГ МИНЬ СУРГУУЛЬД ОРУУЛ!

Бодлогын нөлөөлөлд ашиглах мэдээлэл

Улаанбаатар хот

2024 он

Боловсруулсан: Я.Мөнхчимэг

Б.Батчимэг

Редактор: Д.Тунгалаг

Фото зургийг Д.Давааням

Боловсролын төлөө чанга дуугар! төслийн санхүүжилтээр хэвлэв

EDUCATION OUTLOUD  
advocacy & social accountability

GPE  
Transforming  
Education

# УДИРТГАЛ

Сурч боловсрох нь хүний суурь эрх төдийгүй бусад эрх, эрх чөлөөгөө эдлэх хамгийн чухал эх сурвалж. Чөлөөтэй, өргөн хүрээтэй сэтгэх чадвар бүхий сайн боловсрол эзэмшсэн, идэвхтэй хувь хүн л хүн болж төрсний гавьяа, аз жаргалыг мэдэрдэг. Боловсрол нь чадавхын эрх болохын хувьд нийгэм, эдийн засгийн нөхцөл бололцоогүй хүүхдүүд, залуучуудад ядуурлаас гарах, нийгмийн амьдралд бүрэн төгс оролцох арга замаа олох үндсэн хэрэгсэл нь болдог. Боловсрол нь эмэгтэйчүүдийг чадавхжуулах, хүүхдүүдийг хүнд, хортой хөдөлмөр, бэлгийн мөлжлөгт өртөхөөс хамгаалах болон хүний эрх, ардчиллыг хөхиүлэн дэмжих, хүрээлэн буй орчныг хамгаалах, хүн амын өсөлтийг хянах зэрэгт нэн чухал үүрэгтэй. Төрийн зүгээс хийж болох хамгийн сайн хөрөнгө оруулалт бол бүх нийтийн боловсролд зориулах төсөв хэмээн эдийн засагчид хүлээн зөвшөөрдөг. Боловсролын ач холбогдол нь зөвхөн хувь хүнд өгөөжтэй биш нийгмийн хөгжил, улмаар улс орны эдийн засгийн хөгжилд эерэг нөлөөтэй тул олон жилийн турш боловсролын салбар Засгийн Газрын бодлогын тэргүүлэх чиглэл байсаар ирсэн, одоо ч хэвээр байна.

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл (Боловсрол эвсэл) байгуулагдсан цагаасаа сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг шахаж, үүрэг хүлээгчдээс хариуцлага нэхэх чиглэлээр бодлогын нөлөөллийн ажил хийж ирсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд сургууль завсардсан хүүхдүүд, улмаар сургууль завсардах нөхцөлд хүргэж буй нийгэм эдийн засаг, соёлын хүчин зүйлсийг судалж, тодорхойлохоор ажиллаж байна.

# ХЭН? АНХААРАХ АСУУДАЛ 1

## ОРХИГДСОН БҮЛГҮҮД

Монгол Улсын иргэн бүр сурч боловсрох эрхтэй, төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгоно хэмээн заасан ч өөрөөс үл шалтгаалах нөхцөл байдлаас болж эрхээ эдэлж чадахгүй, тогтолцооноос гээгдэж буй онцгойлон анхаарах шаардлагатай бүлгүүд олон. Боловсрол эвсэл 2019 оноос эхлэн гишүүн байгууллагууд, салбар зөвлөлүүдээр хэлэлцэн, сурч боловсрох эрх нь зөрчигдөж буй 20 гаруй бүлгийг тодорхойлон, тулгарч буй саад тотгорын улмаас тэдгээр бүлгүүд боловсролын гадна үлдэж, чанартай боловсрол авч чадахгүй эрсдэлтэйг онцолж ирсэн. Тухайлбал,

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд
- Үндэстний цөөнхийн хүүхдүүд (казак, тува)
- Нийгэм эдийн засгийн статус доогуур өрхийн хүүхдүүд
- Шилжин суурьшигч өрхийн хүүхдүүд
- Бэлгийн цөөнх хүүхдүүд
- Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид (бэлгийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтад өртсөн)
- Хурдан морь унадаг унаач хүүхдүүд
- Дотуур байрны хүүхдүүд
- Бичил уурхайд ажилладаг, албан бус хөдөлмөр эрхэлдэг өрхийн хүүхдүүд
- “Тавиул” гэгдэх айлд амьдардаг хүүхдүүд
- Өрх толгойлсон (дүү нараа хараад эцэг эхээсээ тусдаа байдаг)

хүүхдүүд зэрэг газар нутгийн өргөн уудам, хүн амын тархай бутархай байдал, нүүдэлчин ахуйтай холбоотойгоор өвөрмөц бүлгүүд үүсэж буйг бодлогын түвшинд анхаарах, ялгаатай хэрэгцээг хангахыг чармайх ёстой.

Боловсрол эвсэл өнгөрсөн жилүүдэд 4-5 маргинал<sup>1</sup> бүлгийг сонгон тэдэнд сурч боловсрох эрхээ эдлэхэд тулгарч буй саад тотгор, сурахад шаардлагатай эрэлт, хэрэгцээг илрүүлэх, нөхцөл байдлыг тодотгох зорилготой чанарын, бодлогын болон кейс судалгаа, бодлогын хэрэгжилтийн үнэлгээ, мониторинг хийж асуудалд ул суурьтай хандаж нотолгоонд суурилсан бодлогын нөлөөлөл хийж байна. Маргинал бүлгийн хүүхдүүд сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй байхад нийгэм эдийн засаг, тогтолцооны ялгаварлан гадуурхалт гэх мэтийн олон хүчин зүйлс нөлөөлдөг болохыг илрүүлсэн.

Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох “Алсын хараа - 2050” бодлогын баримт бичиг болон Боловсролын ерөнхий хуульд хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлэх чухал зорилтыг дэвшүүлсэн байдаг. Мөн Боловсролын ерөнхий хуулийн 10.2.5-д заасны дагуу 12 жилийн ерөнхий боловсролыг заавал эзэмшихээр заасан байдаг ч бодлого зохицуулалтын уялдаа холбоо, салбар хоорондын хамтын ажиллагаа хангалтгүйн улмаас мянга мянган хүүхэд боловсролын гадна үлдсээр байна.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээгээр 2018-2019 оны хичээлийн жилд бага ангид хамрагдвал зохих 6-10 насны нийт хүүхдийн 5,5% буюу 15.3 мянган хүүхэд, дунд ангид хамрагдвал зохих 11-14 насны нийт хүүхдийн 7,4% буюу 13.8 мянган хүүхэд (үүнээс эрэгтэй 56%, эмэгтэй 44%) сургуульд хамрагдаагүй байна. Сургуульд хамрагдаагүй 29,152 хүүхдийг ялгаатай хэрэгцээгээр нь тодорхой ангилан гаргадаггүй байв. Харин 2021-2024 оны Боловсролын яамны статистик мэдээгээр 6-14 насны сургуулийн гадна байгаа хүүхдийн статистик (давхацсан тоогоор) 2020-2021 онд 776 (үүнээс 615 нь сургуульд огт ороогүй, 161 нь завсардсан, малчдын хүүхэд 114), 2021-2022 онд 987 (үүнээс 810 нь огт ороогүй, 177 нь ороод завсардсан, малчдын хүүхэд 108), 2022-2023 онд 656 (502 огт ороогүй, 154 ороод завсардсан, малчдын хүүхэд 89), 2023-2024 онд 454 (огт ороогүй 357, завсардсан 97, малчдын хүүхэд 231) хүүхэд байна гэжээ.

---

1 Орхигдож үлдсэн бүлэг- БШУЯ, ЮНЕСКО ТХЗ 4 хэрэгжилтийн дунд хугацааны үнэлгээний тайлан, 2022 он

# ХЭРХЭН? АНХААРАХ АСУУДАЛ 2

## НЭРШИЛ, АНГИЛАЛ, ТОДОРХОЙЛОЛТ, ҮЗҮҮЛЭЛТ

НҮБ-ын Хүүхдийн Сан ба ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэн хамтран 2010 онд эхлүүлсэн Сургуулийн гадна байгаа хүүхдэд чиглэсэн санаачилгын хүрээнд ашиглаж байгаа үзэл баримтлалын хүрээгээр сургуулийн гадна байгаа хүүхдүүдийг **өмнө нь сургуульд ороод гарсан** ба **хэзээ ч сургуульд ороогүй** хүүхдүүд гэж 2 ангилж үзсэн байна.

Сургуулийн гадна байгаа 1-3 хэмжээст хүүхдүүд боловсролоос гадуурхагдсан бол сургуульд байгаа буюу 4 ба 5 дах хэмжээст багтах хүүхдүүд боловсрол дотроо гадуурхалд (ялгаварлан гадуурхсан практик, багшийн хандлага зэргээр) өртдөг гэсэн үг.

### БОЛОВСРОЛЫН ГАДУУРХЛЫН 5 ХЭМЖЭЭС

<b>ХЭМЖЭЭС 1</b> Сургуулийн өмнөх болон бага боловсролд байхгүй байгаа	<b>ХЭМЖЭЭС 2</b> Хамрагдаж байсан боловч завсардсан   Хожим дахин элсэж орно   Хэзээ ч эргэж орохгүй	<b>ХЭМЖЭЭС 3</b> Хамрагдаж байсан боловч завсардсан   Хожим дахин элсэж орно   Хэзээ ч эргэж орохгүй	 <b>Сургуулийн гадна байгаа</b>
<b>Сургуулийн өмнөх боловсролын насны хүүхэд</b>	<b>Бага боловсролын насны хүүхдүүд</b>	<b>Дунд боловсролын насны хүүхдүүд</b>	
	<b>ХЭМЖЭЭС 4</b> Бага ангиас/сургуулиас завсардах эрсдэлтэй хүүхдүүд	<b>ХЭМЖЭЭС 5</b> Дунд ангиас/сургуулиас завсардах эрсдэлтэй хүүхдүүд	 <b>Сургуульд байгаа</b>
	<b>Бага сургуулийн сурагчид</b>	<b>Дунд сургуулийн сурагчид</b>	



# БОЛОВСРОЛООС ОРХИГДОГЧДЫН ДҮР ТӨРХ

## ХЭМЖЭЭС 1:

### Сургуулийн өмнөх боловсролын насны сургуулийн гадна байгаа хүүхдүүд

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн (4.3 заалт) дагуу 5 настай хүүхэд сургуулийн өмнөх боловсролд заавал хамрагдах ёстой. Улс орнуудад хамгийн ядуу өрхийн (нийгэм-эдийн засгийн статус доогуур) өрхийн хүүхдүүд энэ хэмжээст багтаж байна.

## ХЭМЖЭЭС 2:

### Бага сургуулийн насны сургуулийн гадна байгаа хүүхэд

Амьжиргааны түвшин, амьдран суугаа газар (хотын зах, хөдөөгийн баг, малчны хүүхэд), хөгжлийн бэрхшээл, үндэстний цөөнх, хөдөөгөөс хот руу шилжилт хөдөлгөөн зэрэгтэй холбоотойгоор 1-р ангид орж чадахгүй байгаа хүүхдүүд энэ хэмжээст багтана.

## ХЭМЖЭЭС 3:

### Дунд ангид байх насны сургуулийн гадна байгаа өсвөр үеийнхэн

Ихэнх улс оронд дийлэнх нь сургуульд орсон ч сургууль завсардсан хүүхдүүд байна.

Амьжиргааны түвшин, амьдран суугаа газар (хотын зах, хөдөөгийн баг, малчны хүүхэд), хөгжлийн бэрхшээл, үндэстний цөөнх, хөдөөгөөс хот руу шилжилт хөдөлгөөн зэрэгтэй холбоотойгоор завсардаж байгаа ба ядуу өрхийн хүүхдийн хувьд “хүүхдийн хөдөлмөр” гэдэг шалтгаан нэмж орж ирж байна.

## ХЭМЖЭЭС 4:

### Бага сургуулийн насны сургуулиас завсардах эрсдэлтэй байгаа хүүхэд

Дийлэнх улс оронд бага сургуулийн төгсөх ангиас завсардах явдал гарч байна. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах нь хүүхдийн бага сургуулийг бүрэн дүүргэх урьдач нөхцөл гэдэг нь тодорхой болж байна.

## ХЭМЖЭЭС 5:

### Дунд ангиас сургууль завсардах эрсдэлтэй өсвөр үеийнхэн

Нас хэтэрч элссэн хүүхдүүд болон хөвгүүд сургууль завсардах эрсдэл өндөр байна.

Монгол улсад “Боловсролын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал”<sup>2</sup>-ын дагуу 2 төрлийн үзүүлэлтийг тооцож гаргадаг.

#### 20 IV.2.6 СУРГУУЛИЙН ГАДНА БАЙГАА ХҮҮХДИЙН ТОО

**Зорилго:** Бүх нийтээр анхан шатны боловсрол эзэмших бодлогын хэрэгжилтийг хангах, үнэлэхэд оршино.

**Үзүүлэлтийн тодорхойлолт:** Сургуулийн гадна байгаа хүүхдийн тоо гэж албан ёсоор сургуулийн насны боловч сургуульд огт хамрагдаагүй хүүхдүүдийн тоог хэлнэ.

**Тооцох арга зүй:** Тухайн насны элсэгчдийн тоог албан ёсны боловсрол эзэмшвэл зохих насны нийт хүүхдийн тооноос хасч тооцно.

**Мэдээллийн эх үүсвэр, давтамж:** Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статистикийн мэдээ, ҮСХ-ны суурин хүн амын мэдээгээр жил бүр тооцно.

**Мэдээллийн задаргаа:** Улсын түвшин, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, хүйсээр тооцно.

#### IV.2.7 СУРГУУЛЬ ЗАВСАРДАГЧДЫН ХУВИЙН ЖИН

**Зорилго:** Үргэлжлүүлэн суралцаагүй завсардалтыг тооцох, түүний үр дагавар нь боловсролын системийн дотоод үр ашигт хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлоход оршино.

Сургууль завсардагчдын хувийн жин нь боловсролын системийн дотор суралцагчдын шилжилт, хөдөлгөөнийг тооцоход чухал үзүүлэлт болдог.

**Үзүүлэлтийн тодорхойлолт:** Өмнөх хичээлийн жилд тодорхой анги, бүлгийн суралцагчид тухайн хичээлийн жилд үргэлжүүлэн суралцаагүй байвал сургууль завсардалт гэж үзнэ.

**Тооцох арга зүй:** Сургууль завсардагчдын хувийн жинг гаргахдаа тухайн хичээлийн жилд анги дэвшсэн болон улирсан суралцагчдын эзлэх хувийн нийлбэрийг 100 хувиас хасна. Бага боловсролын сургууль завсардалтын хувьд, тухайн ангид дэвшин орж чадсан суралцагчдын эзлэх хувийг 100 хувиас хасна

**Мэдээллийн эх үүсвэр, давтамж:** Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статистикийн мэдээгээр жил бүр тооцно.

**Мэдээллийн задаргаа:** Улсын түвшин, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, боловсролын түвшин, өмчийн хэлбэр, анги, бүлэг, хүйсээр тооцно.

2 ҮСХ-ны даргын 2013 оны 12 сарын 16-ны өдрийн 01/145 дугаар тушаал

# ХААНА? АНХААРАХ АСУУДАЛ 3

## ӨГӨГДӨЛИЙН ХИЙДЭЛ

Боловсролын яам зарим төрлийн сургуулиас захиргааны тоо статистик цуглуулахгүй байх, тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв, гэрээр боловсрол эзэмшиж буй хүүхэд, хувийн сургууль зэргээс статистикийн мэдээлэл авдаггүй байх тохиолдол гардаг. Тиймээс энэхүү мэдээлэлд сургууль завсардсан болон сургуулийн гадна байгаа хүүхэд гэсэн нэршлийг ашиглалаа. Сургууль звсардсан болон сургуулийн гадна байгаа хүүхдүүдийг “үл үзэгдэгч”, “хагас үзэгдэгч”, “бүрэн үзэгдэгч” гэж 3 ангилж үзэж байна.

### **“Бүрэн үзэгдэгч” гэж хэн бэ?**

Боловсролын яамны дата бааз буюу Боловсролын мэдээллийн технологийн төв<sup>3</sup>д болон бусад засгийн газрын боловсролын дата баазад тодорхойлогддог сургуулийн гадна байгаа хүүхдүүд. Дийлэнх нь сургууль завсардагчид.

### **“Хагас үзэгдэгч” гэж хэн бэ?**

Үнэндээ бол үл үзэгдэгч гэхдээ Засгийн газрын дата баазуудтай тулган шалгахад илрэх, эсвэл сургууль дээрх бүртгэлийг харахад ил болдог хүүхдүүд. Энд 2 бүлгийн хүүхэд хамаарна. Эхнийх нь аль хэдийнэ сургууль завсардчихсан боловч тэгж бүртгэгдээгүй хүүхдүүд. Сургуулиас эхлээд үндэсний түвшин хүртэл мэдээллийн урсгалыг сайжруулахад илэрнэ. Ирцийн мэдээлэл авахад ил болно. Удаах нь сургуульд хэзээ ч хамрагдаж

байгаагүй сургуулийн гадна байгаа хүүхэд. Мэдээллийг хэвтээ чиглэлд буюу салбар дунд солилцоход илрэх болно. Төрсний гэрчилгээний дугаар, регистрийн дугаар гэх мэт хүнд ганц байдаг дугаараар иргэний улсын бүртгэлээс шүүхэд гарч ирэх боломжтой.

### “Үл үзэгдэгч” гэж хэн бэ?

Засгийн газрын болон засаг захиргааны бүртгэлд, сургууль дээрх бүртгэлд огт бүртгэгдээгүй тул үл үзэгдэгч хүүхдүүд. Хамгийн эмзэг, хүрч очих боломжгүй хүүхдүүд байх нь олонтаа.



Маргинал бүлгийн хүүхдэд хэд хэдэн шинж хослох, гурамслах, давхцах (intersectional issue) нь тэдгээрийг сургуульд элсэн орох, үргэлжлүүлэн суралцах, цаашлаад чанартай боловсрол эзэмших боломжид шууд сөргөөр нөлөөлж, тэдгээрийн эрсдэлт нөхцөлийг улам бүр доройтуулж байгаад анхаарал хандуулах шаардлагатай. Тэр дундаа нийгэм эдийн засгийн статусаас үүдсэн ядуурал, тэгш бус байдал хүүхдийн боловсрол эзэмших боломжийг суурь шинжтэйгээр тодорхойлж, сурч боловсрох эрхийн хэрэгжилтэд нөлөөлж байна.

**Матриц 1. Зорилтот бүлгийн шинжийн хослол, гурамслал<sup>4</sup>**

<b>Зорилтот бүлэг</b>	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	Алслагдмал нутагт амьдардаг хүүхэд	Амьжиргааны түвшин доогуур өрхийн хүүхэд
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд		Өндөр эрсдэлтэй	Өндөр эрсдэлтэй
	<b>Нэн өндөр эрсдэлтэй</b>		
Алслагдмал нутагт амьдардаг хүүхэд	Өндөр эрсдэлтэй		Өндөр эрсдэлтэй
	<b>Нэн өндөр эрсдэлтэй</b>		
Амьжиргааны түвшин доогуур өрхийн хүүхэд	Өндөр эрсдэлтэй	Өндөр эрсдэлтэй	
	<b>Нэн өндөр эрсдэлтэй</b>		

**Тодруулбал,** алслагдмал нутагт амьдардаг, амьжиргааны түвшин доогуур өрхийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуульд суралцах боломж хомс, чанартай боловсрол эзэмших бараг боломжгүй. Алслагдмал нутагт амьдардаг, амьжиргааны түвшин доогуур өрхийн хүүхэд сургуульд хамрагдах ч чанартай боловсрол эзэмших боломж хязгаарлагдмал. Алслагдмал нутагт амьдардаг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй бол сургуульд хамрагдах боломжоор дутмаг чанартай боловсрол эзэмших боломж хязгаарлагдмал. Амьжиргааны түвшин доогуур өрхийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуульд хамрагдах боломжоор дутмаг чанартай боловсрол эзэмших бараг боломжгүй. Өрхийн амьжиргааны түвшин хүүхдийн боловсрол эзэмших боломжийг суурь шинжтэйгээр тодорхойлж байгааг Олон улсын сурлагын амжилтын үнэлгээний (PISA)<sup>5</sup> дүн баталсан.

4 Зорилтот бүлгийн хүүхдийн боловсролын хэрэгцээ, асуудлууд, 2020 он, С.Түмэндэлгэр

5 PISA 2022 Mongolia National report, MOES, OECD, 2023

# ЯАГААД? АНХААРАХ АСУУДАЛ 4

## ХҮҮХЭД, ӨСВӨР ҮЕИЙНХЭНД СУРГУУЛЬД ХАМРАГДАХ, БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХЭД ТУЛГАРАХ СААД

Тодорхой саадын улмаас хүүхэд сургуульд суралцаж чадахгүй эсвэл боломжгүй болдог. Тодорхой саад гэдэгт гэр бүлийн түвшинд (нийгэм-эдийн засгийн, хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, жендэрийн ялгаварлан гадуурхалт, гэр бүлийн хүчирхийлэл, эцэг эхийн үл хайхралт), сургуулийн түвшинд (дэд бүтэц, алслагдмал, сургуулийн соёл, үе тэнгийн дээрэлхэл, ялгаварлан гадуурхал, дотуур байрны хүрэлцээ), бодлогын түвшинд (сургуулийн хүртээмж, багшийн чанар, сул зохицуулалт, бодлогын хэрэгжилтийн уялдаа холбоогүй байдал, боловсролд тэгш хамруулах үйл явцыг дэмжих механизм дутмаг, хангалттай санхүүжилтгүй) илэрдэг бөгөөд эдгээр нь хүүхдээс өөрөөс нь шалтгаалаагүй байдаг.

Хүүхдийн суралцах, боловсрол эзэмшихэд мөнгө санхүүгийн бэрхшээл, ядуурал, амьжиргааны түвшний дорой байдал хамгийн ихээхэн нөлөөлж байна<sup>6</sup>. Гэр бүлийн амьжиргаанд тус нэмэр болох үүднээс хөдөлмөр эрхлэх, мал маллах болсноор сургууль завсарддаг нийгэм эдийн засгийн статус доогуур өрх, малчин айл өрхийн хөвгүүдийн дунд боловсрол эзэмших боломж хязгаарлагдмал байдаг. Тухайлбал сургууль завсардсан 8-15 насны нийт хүүхдийн 60 орчим хувийг ядуу, малчин айлын хөвгүүд эзэлж байна гэсэн дүгнэлт төдийлөн өөрчлөгдөөгүй хэвээр байгаа юм<sup>7</sup>.

Сургуульд жил нэгээр нэмэгдэхэд хөдөлмөр эрхлэх магадлал 6.5 хувиар

6 “Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгорууд” (чанарын судалгаа) 2020 он, Боловсрол эвсэл

7 “Алсын хараа 2050: Боловсролын салбарт эрх тэгш байдал, үр ашиг, үр дүнг нэмэгдүүлэх нь” тайлан, 2021 он, АХБ,

нэмэгддэг<sup>8</sup> гэсэн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа бий. НҮБ-ын Хүүхдийн сан, НТБТ-тэй хамтран 2018 онд БЗД-ийн 28 хорооноос гэр хороолол бүхий 4 хорооны нийт өрхийн дунд сургууль завсардсан хүүхэд, насанд хүрэгч, бичиг үсэг үл мэдэгч иргэдийг илрүүлэх зорилгоор 11466 өрхөд<sup>9</sup> судалгаа хийжээ. Дээрх судалгаагаар сургууль завсардсан хүүхдүүдийн 63.7 хувь нь эрэгтэй, 36.5 хувь эмэгтэй хүүхэд байсан бөгөөд сургуулийн насны боловч сургуульд хамрагдаагүй 96 хүүхэд байсны 24 (25%) нь сургуульд огт элсэн орж байгаагүй, 64 (66,7%) нь сургууль завсардсан (8 хүүхэд-8.3%). Эдгээр 96 хүүхдийн 26 (27%) нь хөгжлийн бэрхшээлтэй байсан бол 28.1 хувь нь 6-11 настай, 21.9 хувь 12-14; 50 хувь нь 15-18 настай байсан нь сургууль завсардагчдын нас нэмэгдэх хандлагатай байгааг харуулж байна. Тус судалгаагаар 18 ба түүнээс дээш насны 502 хүн зохих шатны сургуулиа дүүргээгүй (завсардсан) байсны 46%<sup>10</sup> нь **бичиг үсэг үл мэдэгч** байв. Судалгаагаар илэрсэн сургууль завсардсан хүүхдүүдийн 34.4 хувь нь “хүүхэд төрүүлсэн”, “лам болсон”, “баримт бичиг огт байхгүй”, “сурах дургүй”, “бага насны хүүхэд харсан”, “ар гэрийн үл хайхрах байдал” гэж хариулсан бол үлдсэн хувь нь шилжилт хөдөлгөөн, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээл, амьжиргааны түвшин доогуур байдлаас гадна үе тэнгийнхний дарамт, хөгжлийн бэрхшээл, багшийн эвгүй харилцаа нөлөөлсөн гэж үзжээ.

Азийн Хөгжлийн Банкны мэдээлснээр<sup>11</sup> сургуулийн гадна буй хүүхдүүдийн 81% нь хувийн шалтгаанаар, 14.3% нь гэр бүлтэй холбоотой шалтгаанаар, 2% нь сургуультай холбоотой шалтгааны улмаас сургуулиас гарсан гэж мэдэгдсэн. Асран хамгаалагч болон эцэг эхчүүдийн тайлбарласнаар сургуулиас гарахад нөлөөлсөн хувийн шалтгаанууд нь (давтамжийн дарааллаар) эрүүл мэндийн байдал, сурах сонирхолгүй байдал, өөрийгөө илэрхийлэх болон бусад хүмүүстэй харилцах чадваргүй эсвэл чадвар сул байдал гэжээ. Харамсалтай нь сургуулийн гадна буй хүүхдийн 81% нь хувийн шалтгаанаар сургуульдаа явахаа больсон гэж үзэж байгаа нь хүүхдийг буруутгасан хандлага ажиглагдаж байна.

Амьжиргааны түвшиндоогуур өрхийн хүүхдүүд үе тэнгийнхний ялгаварлан гадуурхалтад өртөж буй мэт сэтгэгдэлтэй байдаг талаараа Боловсрол эвслийн судалгаанд<sup>12</sup> хуваалцсан. Тухайлбал, тэд багш нарынхаа талаар сөрөг сэтгэгдэлтэй байгаа нь “ялгаварлан гадуурхагддаг мэдрэмж төрдөг”,

8 “Боловсрол ба хөдөлмөр эрхлэлт”, 2020 он

9 Статистик мэдээлэлд 13310 өрх бүртгэгдсэн боловч 1844 нь хаягандаа байгаагүй, хасалт хийлгээгүй байсан.

10 Бичиг үсэг үл мэдэгчдийг насны бүлгээр авч үзвэл 63.2% нь 18-35 насныхан, түүний дотор эрэгтэйчүүд зонхилж байна. Эндээс үзэхэд шилжин сууршигчид ба амьдралын доогуур түвшинд аж төрөгчдийн дотор нийгэмд тодорхой байр суурь эзлэх насандаа хүрсэн, эдийн засгийн хамгийн идэвхтэй хүн амын хэсэг болох идэр насны эрэгтэйчүүдийн боловсрол муу байгааг анхаарах шаардлагатай.

11 АХБ-ны ЗҮҮН АЗИЙН газраас эрхлэн гаргадаг ТЕХНИКИЙН ЦУВРАЛ ТАЙЛАН, дугаар 28, 2020 он <https://www.adb.org/sites/default/files/publication/720336/eawp-28-inclusive-education-mongolia-mn.pdf>

12 Зорилтот бүлгийн хүүхдийн боловсролын хэрэгцээ, асуудлууд, 2020 он, С.Түмэндэлгэр

2022 онд бага боловсролын гадна байгаа

хүүхдийн тоо **20,338**

байсан хэмээн Дэлхийн банкны статистик мэдээнд тэмдэглэгджээ.

<https://data.worldbank.org/indicator/SE.PRM.UNER>

“суралцахад анхаарч зөвлөгөө өгдөггүй” гэсэн хариултаас харагдана. Гэр сургууль хооронд зорчих нийтийн тээврийн үйлчилгээ байхгүй, сургуулийн автобусаар үйлчилдэггүй нь өдөр бүр сургууль руу явахад бэрхшээл үүсгэдэг, хичээлийн хэрэгсэлгүйгээс даалгавраа хийж чадахгүйд хүрдэг, өлсдөгөөс хичээлээ ойлгохгүйд хүрдэг, хичээлийн үйл явцад бараг оролцдоггүй хойгуур суудаг хэмээн өгүүлсэн нь хувь хүнээс хамаарсан гэхээсээ тогтолцооны шинжтэй саад байгаа нь харагдана.

Сургуулиас гарахад нөлөөлсөн гэр бүлтэй холбоотой шалтгаанууд нь сургуульд суралцахтай холбоотой зардлыг төлөх боломжгүй байдал, шилжин суурьшилтаас үүдсэн асуудлууд, шаардлагатай бичиг баримтгүй байх, хүүхдийг сургуульд хүргэж өгөх болон сургуулиас авах хүнгүй байх явдал байна. Сургуультай холбоотой шалтгаануудад үе тэнгийнхний зүгээс дээрэлхэх явдал, багш нар болон сургуулийн бусад ажилтнуудын зүгээс үзүүлэх дарамт шахалт байна.<sup>13</sup> Боловсрол эвслийн судалгаанд оролцсон сургуулиудын 50 гаруй хувь, орон нутгийн нэгжийн 50 орчим хувь нь хамран сургах тойргийнхоо сургуулийн насны бүх сурагчдыг бүрэн хамруулж чаддаг гэж хариулжээ. Гэвч сургууль, орон нутгийн нэгжүүд аль аль нь “сургуулийн насны бүх хүүхэд сургуульд хамрагдаж чадахгүй байгаа” гэдэгтэй санал нийлжээ.<sup>14</sup> Орон нутгийн засаг захиргааны нэгжийн хувьд хэлний бэрхшээлтэй, хот амьдрах айл байхгүйгээс, ажил хийх хэрэгтэй учраас, эцэг эх нь явуулдаггүй, дотуур байрны хүрэлцээгүйгээс, 6 настайгаас сургуульд оруулдагаас (сумдын сургуулиудаас ирсэн хариу), өрхийн бүртгэлгүй, харьяаллын бус, түр оршин сууж байгаа (хотын сургуулиудаас ирсэн хариу) зэрэг нь хүүхэд сургуулийн гадна үлдэхэд хүргэж байна хэмээн үзсэн.

Боловсролын ерөнхий хууль батлагдсанаар сургуулийн гадна байгаа хүүхдийн сургуульд суралцахгүй байгаа шалтгааныг ялгаатай хэрэгцээгээр нарийвчлан гаргаж эхэлсэн нь сайшаалтай. Боловсролын яамны мэдээгээр суралцахгүй байгаа шалтгаанд амьдралын гачигдал, сурах дургүй, ажил эрхлэх, өвчний улмаас, бүтэн хагас өнчин, асрамжлах хүнгүй, хөгжлийн бэрхшээлийн улмаас гэжээ. Гэвч “амьдралын гачигдал”, “сурах дургүй” гэсэн асуудлын цаана нийгэм-эдийн засгийн бололцоо, боловсролын тогтолцооны ямар асуудал нуугдаж буйг таахад бэрх юм.

13 АХБ-ны ЗҮҮН АЗИЙН газраас эрхлэн гаргадаг ТЕХНИКИЙН ЦУВРАЛ ТАЙЛАН, дугаар 28, 2020 он <https://www.adb.org/sites/default/files/publication/720336/eawp-28-inclusive-education-mongolia-mn.pdf>

14 Мөн тэнд гэдгийг хасаад Зорилтот бүлгийн боловсрол гэсэн эшлэлийг оруулах



Сургууль завсардсан болон сургуулийн гадна байгаа шалтгааныг тодорхойлохдоо зөвхөн хүүхдийн нөхцөл байдлаас болсон мэт гаргаж байгаа нь хүний эрхэд суурилсан хандлага-арга зүйд нийцэхгүй байна. Хүний эрхэд суурилсан хандлага-арга зүйгээр авч үзвэл бүх хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах нь төрийн хүлээх үүрэг бөгөөд хүүхдэд эрхээ бусдын адил эдлэхэд тулгарч байгаа саад тотгорыг тодорхойлж, арилгах нь боловсролын тогтолцооны асуудал, боловсролын бодлого, санхүүжилтээр шийдэх асуудал гэж харвал зохино. Маргиналчлагдсан, эмзэг бүлгийн хүүхдийг боловсрол эзэмшихэд хамгийн их нөлөөлж буй нь санхүүгийн саад тотгорууд байна. Энэ нь боловсролын төсөв хүүхдийн ялгаатай байдалд мэдрэмжгүй, эрх тэгш байдалд суурилагагүй байгаатай холбоотой<sup>15</sup> гэж судлаачид үзсэн.

Сургууль завсардсан болон сургуулийн гадна байгаа хүүхдүүдэд тулгардаг нийтлэг саадуудыг дараах байдлаар авч үздэг.<sup>16</sup>

## ЭРЭЛТ ТАЛЫН СААД БЭРХШЭЭЛ



### Сургуультай холбоотой төлбөр, зардлууд

Сургуулийг үнэ төлбөргүй болгох ба нийгэм-эдийн засгийн статус доогуур өрхүүдэд чиглэсэн бусад зорилтот бодлого нь бүхий л гэр бүлүүдэд тулгарч буй сургуулийн зардлыг бууруулдаг. Үнэ төлбөргүй үдийн хоолоор хангах (өглөөний цай орно), сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичгээр хангах, сургалтын тэтгэлэг, суралцагчийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн амьжиргааны зардал, хүүхдийн мөнгөн тэтгэмж болон бусад дэмжлэгийн механизмууд нь нэн ядуу өрхийн хүүхдүүдийг боловсролд хамрагдахад дэмжих зорилгоор хэрэгжүүлж буй бодлогууд юм. Сургалтын төлбөргүй байх бодлогоос үл шалтгаалан сургуулиуд төсвийн цоорхойг нөхөх зорилгоор албан болон албан бус хэлбэрээр суралцагчдаас төлбөр хураамж авдаг. Хичээлийн бус цагаар нэмэлт давтлага өгөхдөө суралцагчдаас нэмэлт төлбөр авдаг нь олон оронд байдаг нийтлэг саад тотгор юм. Сургуультай холбоотой гардаг зардал нь сургуульд насандаа элсэж орох, эсвэл сургуулиа төгсөхөд саад болдог.



### Хүүхдийн хөдөлмөр

Хүүхэд, өсвөр үеийнхний хөдөлмөр эрхлэлт нь дийлэнхдээ хөдөө орон нутаг, хамгийн ядуу өрхөд ихэнхдээ тохиолдож байна. Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн ихэнх нь гэр бүлийнхээ хамт хөдөө аж ахуйд ажилладаг. Гэрийн ажил нь охидын боловсролд бүтэн цагийн хөдөлмөр мэт нөлөөлдөг бол ядуу өрхийн хөвгүүдийн хувьд нийгэм, гэр бүлийн зүгээс ажил хөдөлмөр эрт эрхлэх дарамт үүсгэдэг. Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд, өсвөр үеийнхнийг хамгаалах хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох ёстой. Нөгөө талаар хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг ажил, боловсролыг хослуулсан албан бус болон нэмэлт боловсролын хөтөлбөрүүдээс үр шим хүртэх боломжтой болгох ёстой.

15 Амьжиргааны түвшин доогуур өрхийн суралцагчийг сурах бололцоогоор хангах талаарх бодлого, түүний хэрэгжилт, 2021 он, Боловсрол эвсэл

16 Learning against the ODDS Evidence and Policies to support all out-of-school children and adolescents in East Asia and Pacific <https://www.unicef.org/eap/media/3836/file/Executive%20Summary%20-%20Learning%20Against%20the%20Odds.pdf>



### Олон улсын болон үндэсний шилжих хөдөлгөөн

Хөдөө орон нутгаас хот руу шилжих шилжилт хөдөлгөөн нь хичээл таслах, анги улиран нас хэтрэх зэрэгтэй холбоотой боловсрол нь тасалдаж, сургуулиас завсардах эрсдлийг нэмэгдүүлдэг. Шилжин ирэгсэд ихэвчлэн чанаргүй төрийн үйлчилгээ үзүүлдэг хотын захын алслагдмал хорооллоор суурьшдаг. Мөн бүртгэлийн систем нь хөдөөнөөс хот руу шилжин ирэгсдийн хувьд боловсролд хамрагдахад тулгарч буй албан ёсны хүнд суртлын саад учруулдаг. Олон улсын шилжигч/цагаачид хүлээн авсан орондоо боловсрол эзэмшихэд янз бүрийн саад бэрхшээлтэй тулгардаг. Ялангуяа амьдрах зөвшөөрөл, баримт бичиг, хэл, ялгаварлан гадуурхалт, гутаан доромжлол, албан бус сургуулийн төлбөр, хүртээмжгүй байдал зэрэг нь боловсролд учирч буй саад хэвээр байсаар байна. Улс орнууд төрийн үйлчилгээг цагаачдад, ялангуяа зөвшөөрөлгүй оршин суугчдад үзүүлэхээс татгалздаг хэвээр.



### Уур амьсгалын өөрчлөлт

Ази-Номхон далайн орнуудын олон орны физик газарзүй нь тэднийг уур амьсгалын өөрчлөлтөд онцгой өртөмтгий болгодог бөгөөд далайн түвшин нэмэгдэх, их хэмжээний үер болох, ургац алдах болон түүнээс үүдэлтэй сөрөг үр дагаварт хүүхэд, өсвөр насныхан хамгийн ихээр өртөх магадлалтай. Хүүхдүүд хоол тэжээл, эрүүл мэнд, амьжиргааны хувьд уур амьсгалын өөрчлөлтөд аль хэдийнэ нэрвэгдэж, энэ нь эргээд сургуульд сурах, үр дүнтэй суралцах чадварт нь нөлөөлж байгааг баримт нотолгоонууд харуулж байна.



### Үндэс угсаа, хэл, нийгмийн хэм хэмжээ

Ихэнхдээ алслагдсан хөдөө орон нутагт амьдардаг үндэстний цөөнхийн хүүхэд, өсвөр насныхан нас хэтэрч сургуульд элсэх, төгсөлтийн түвшин доогуур байх магадлал өндөр байдаг. Үндэстний цөөнхийн хүүхдүүдэд эх хэлээр нь хичээл заахгүй байх нь тэднийг амжилтгүй сурах, улмаар бага ангиасаа сургуулиа орхих магадлалыг ихэсгэдэг. Зарим тохиолдолд үндэстний цөөнхийн бүлгүүдийн соёл, уламжлал нь хүүхдүүдийн, ялангуяа охидын боловсролын боломжид сөрөг нөлөө үзүүлдэг.

Эрт гэрлэлт, өсвөр насны жирэмслэлт, гэр бүл дэх жендэрийн үүрэг хариуцлага, нийгмийн хэм хэмжээ, боловсролд хандах сөрөг хандлага зэрэг нь Зүүн Ази-Номхон далайн бүс нутагт охидын сургуульд суралцах хугацааг богиносгодог хүчин зүйл гэж үзэж байна.



### Хөгжлийн бэрхшээл

Хүүхэд, өсвөр үеийнхний хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох, үйлдлийн чадварыг хэмжих нь улс орон бүрт харилцан адилгүй байдаг бөгөөд боловсролд учирч буй саад бэрхшээлийг арилгахад чиглэсэн зохистой бодлого боловсруулахад хязгаарлагч хүчин зүйл болдог. Төрөл бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, өсвөр үеийнхнийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамруулсан боловсролыг хэрэгжүүлэх нь практикт хүндрэлтэй хэвээр байна. Тусдаа сургууль байх эсвэл ердийн сургуулиуд тусдаа ангитай байх гэх мэт арга замууд ч үр дүнтэй гэсэн хангалттай нотолгоо байхгүй байна. Сургуулиудад хөрөнгө нөөц дутмаг, багш нарын сургалт, ур чадвар хангалтгүй, нийгмийн сөрөг хандлага, ялгаварлан гадуурхалт байсаар байгаа учраас бодлогын түвшинд сайтар тодорхойлсон санаачилга газар дээрээ үр дүнтэй хэрэгжихгүй байх магадлалтай.

## НИЙЛҮҮЛЭЛТ ТАЛЫН СААД БЭРХШЭЭЛ



### Заавал эзэмших боловсролыг эхлэх

Ядуу өрхийн олон хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмших болон бага насны суралцахуйн боломж хомс байдаг. Ази-Номхон далайн ихэнх орнуудад заавал эзэмших албан ёсны боловсрол нь зөвхөн бага боловсролоос эхэлж байна. Гэвч сургалтын үр дүн, суралцахуйд гарч буй ахиц дэвшил олон талын ашиг тустай болохыг нотолж байгаа тул заавал эзэмших боловсролын эхлэх хугацааг эрт байлгах боломжтой.



### Бүртгүүлэх шаардлага

Сургуульд элсэн ороход шаардагддаг төрсний гэрчилгээ нь сургуульд элсэн орох эрхийг хангахад учирч буй захиргааны томоохон саад бэрхшээл болж байна. Ихэнх тохиолдолд төрсний гэрчилгээ авах зардал алслагдсан газар амьдардаг, хөдөө орон нутгийн нэн ядуу өрхийн хүмүүст өндөр хэвээр байна. Шилжин суурьшигч, үндэстний цөөнхийн хүүхэд, өсвөр үеийнхний албан бүртгэлд хамрагдсан байдал нь улсын дунджаас доогуур байдаг. Сургуульд үргэлжлүүлэн суралцахад шаардлагатай насны хязгаар, анги дэвших шалгалтын дүн, оноо, тестийн дүн зэрэг нь дээрх бүлгийн хүүхдүүдэд ахисан түвшний боловсрол эзэмшихэд тулгардаг саад бэрхшээл болсоор байна.



### Багш нар болон суралцахуйн орчин

Хурдтай тэлж буй боловсролын эрэлттэйгээ чанартай мэргэшсэн боловсрон хүчин бэлтгэх явц нь нийцэхгүй байна. Алслагдсан, хөдөөгийн, нийгэм эдийн засгийн статус доогуур бүс нутгуудад багш нарыг илүү эрх тэгш хуваарилах шаардлагатай. Багш нарын хандлага, тэр дундаа жендэрийн өрөөсгөл хүлээлт нь зарим бүлгийн хувьд сургуулиа орхих, суралцахуйн үр дүн буурахад саад болох нөхцөл бүрдүүлдэг. Сургуультай холбоотой хүчирхийлэл (заримдаа жендэрт суурилсан) бэлгийн болон сэтгэл санааны хүчирхийлэл, бие махбодын шийтгэл зэрэг нь хүүхэд, өсвөр үеийнхний хувьд аюултай, ээлгүй, айдастай сургалтын орчныг бүрдүүлдэг.



### Биет хүртээмж

Олон улс орнуудад алслагдсан бүс нутаг дахь бага, дунд сургуулийн хүрэлцээ хангалтгүй байгаа нь суралцахуйн гол саадын нэг байсаар байна. Хөдөө орон нутагт сургуульдаа (ялангуяа дунд сургууль) явах зам хол зайтай, нийтийн тээврийн үйлчилгээ хүртээмжгүй зэрэг нь олон хүүхэд, өсвөр насныхан, тэр дундаа охидыг сургуульд үргэлжлүүлэн суралцах хүсэлгүй болгодог. Хөдөө орон нутагт бага сургууль л байдаг, дунд боловсрол бүрэн олгохгүй, эсвэл холимог бүлгээр хичээллэдэг зэрэг саад ч тохиолддог. Дэд бүтэц, сургуулийн барилга байгууламж тааруу, тэр дундаа ус, ариун цэврийн байгууламжийн хомсдол нь хүүхэд, өсвөр үеийнхэн, хөгжлийн бэрхшээлтэй суралцагсдад саад болж байна.



### Суралцахуй болон сургалтын хөтөлбөрийн нийц

Зарим сургалтын хөтөлбөрүүдийн нийцгүй байдлыг арилгахын тулд амьдрах ухааны ур чадвар олгох (21-р зууны ур чадвар гэгддэг) зэрэг чадамжид суурилсан болгох, хүүхэд төвтэй, жендэрийн ялгаатай байдалд нийцсэн сургах арга зүйг нэвтрүүлэхийг илүүтэй хичээж байна. Ази- Номхон далайн бүсийн хэд хэдэн орон эх хэл дээр суурилсан олон хэлний боловсролыг зохих багш бэлтгэх, үндэстний цөөнхийн болон уугуул иргэдээс багш элсүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах замаар суралцахуйг дэмжиж байна. Гэсэн хэдий ч хамрах хүрээ, нөөц хязгаарлагдмал хэвээр байна.



### Боловсролын санхүүжилт

Ази-Номхон далайн бүсийн олон орны боловсролын зардал олон улсын зөвлөмжөөс доогуур (ДНБ-ий 4-6 хувь буюу улсын төсвийн 15-20%), суурь боловсролд анхаарахгүй хэвээр.

Сургуулийн үйл ажиллагааны төсвийг нөхөхийн тулд эцэг эхчүүдээс янз бүрийн хураамж авдаг тул “төлбөргүй боловсрол” нь өрхийн зардлыг нэмэгдүүлэх хандлагатай байна. Нийгэм эдийн засгийн статус доогуур хүн амыг боловсролд хамруулах хамгийн үр дүнтэй арга замуудын нэг бол эрх тэгш байдлыг хангах багц санхүүжилтийг зарцуулах үйл явц, төвлөрлийг сааруулсан санхүүжилтийн механизмаар дамжуулан хамгийн хэрэгцээтэй газарт төсөв санхүүг чиглүүлэх явдал юм. Үүнд жижиг эсвэл нийгэм эдийн засгийн статус доогуур байршилд байрладаг сургуулиудын асуудлыг шийдсэн эрх тэгш байдлыг бий болгосон санхүүжилтийн тогтолцоо чухал бөгөөд энэ нь өрх гэр бүлээс гарах зардлыг нөхдөг. Мөн илүү шинэлэг санхүүжилтийн механизм/хэрэгсэл нэвтрүүлэх шаардлагатай байна.

# ЯАХ ВЭ? АНХААРАХ АСУУДАЛ 5

## ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Олон улсын байгууллагууд маргинал бүлгийн хүүхдүүд сургуульд суралцахад тулгарч буй саад тотгорын байдлаар нь “хүрч очиход амархан, хүрч очиход хэцүү, хүрч очиход хамгийн хүнд хүүхдүүд” гэсэн 3 категорт<sup>17</sup> ангилж үзсэн байдаг. Үүнд,

Хүрч очиход амархан хүүхдүүд	Хүрч очиход хэцүү хүүхдүүд	Хүрч очиход хамгийн хэцүү хүүхдүүд
<p>Тодорхойлоход хялбар, цөөн тооны саад тотгор байгаа тул амархан хүрч очиж, сургуульд хамруулж болно.</p> <p>Нэг шинж чанар бүхий хүн амын бүлэг байх бөгөөд эрэлт нийлүүлэлтийн талын 1-2 саад тотгор тулгардаг байх магадлалтай. Тухайлбал, нийгэм- эдийн засгийн статус доогуур өрхийн хүүхэд байвал дүрэмт хувцас, сурах бичиг, 4 улирлын хувцас, хичээлийн хэрэгслийг худалдан авч өгөх, үдийн хоол хөтөлбөрт хамруулах, эцэг эхийн оролцоог хангах замаар дээрх саад тотгоруудыг арилгаж болно.</p>	<p>Эдийн засаг, нийгмийн хүчин зүйлүүд давхардан үйлчилж байгаа үед асуудлыг шийдэхэд амаргүй, хүүхдэд хүрч очиход хүнд хэцүү байх тохиолдол.</p> <p>Тухайлбал үндэстний цөөнхийн төлөөлөл болсон малчин өрхийн хүүхэд байвал дэд бүтцийн, хандлагын, ядуурал, мал маллахад туслах үүрэг гэх мэт шийдвэрлэхэд хүнд эрэлт, нийлүүлэлтийн олон тооны хийгээд шийдэхэд хүнд саад тотгорууд байна гэсэн үг.</p>	<p>Нөхцөл байдал, нийгэм, эдийн засгийн сүлжилдсэн ярвигтай хүчин зүйлийн улмаас хувь хүн рүү нь чиглэсэн эрэлт хэрэгцээнд нь тааруулсан арга хэмжээ тусгайлан авах шаардлагатай хүүхдүүд.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй охид, хүүхэд төрүүлсэн охид зэрэг багтана.</p>

<sup>17</sup> Тодорхой бүлгийн хүүхдүүд боловсрол эзэмшихэд тулгардаг саад, тотгорууд, 2020 он, Батбаатар (Боловсрол эвсэл)

Манай улсад сургууль завсардсан болон сургуулийн гадна буй хүүхдүүдийг сургуульд хамруулахын тулд сургууль, орон нутгийн зүгээс дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж байна:

1. Сургуульд хамруулах хэрэгтэй хүүхэд, сургуулийн гадна үлдсэн хүүхдийг олж илрүүлэх ажил зохион байгуулж,
2. Орон нутгийн нэгжийн иргэний бүртгэл, мэдээллийн системд тулгуурлан,
3. Хамтарсан багаар ажиллах,
4. Насан туршийн боловсролын төв, багштай хамтран ажиллах гэсэн хэлбэрээр сургууль орон нутгийн нэгж хамтран ажиллаж эхэлж байгаа юм байна.

Харин сургуулийн зүгээс гэр бүл, эцэг эхчүүд рүү шууд чиглэсэн ажиллагаа дутмаг, орон нутгийн засаг захиргааны нэгж, сургуулийн аль алинд иргэний бүртгэлгүй, түр оршин суугчдын хүүхдийг сургуульд хамруулах чиглэлд дутмаг анхаарч байна. Орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдээс иргэдийг бичиг баримтжуулж, улмаар хүүхдийг нь сургуульд хамруулахаар анхаарч ажиллаж байгаа цөөн тохиолдол байгаа ч хангалтгүй. Бүртгэлгүй бол тухайн орон нутгийн иргэн биш, сургуулийн хувьд тухайн тойрогт хамаарах хүүхэд биш гэсэн хандлагын нөлөөгөөр олон хүүхэд сургууль завсардаж, сургуулийн гадна үлдэж байна.

## **БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ** .....

Тэгш хамруулан сургах боловсрол нь ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг халан, суралцагчдын харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ чадвар, онцлог шинж, сурах хүсэл эрмэлзлэлийг нь хүндэтгэн үзэж бүх нийтэд чанартай боловсрол олгоход чиглэсэн үйл явц юм. Хүн болгон өөрийн гэсэн онцлог шинж чанар, сонирхол болон сурах хэрэгцээтэй учраас тухайн хүний бие бялдар, оюун ухаан, нийгэм-сэтгэл зүй, хэлний болон бусад нөхцөл байдлаас үл шалтгаалан амжилттай суралцах эрхтэй. Энэ үйл явцын хүрээнд боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, суралцах, хөгжих үйл явцад оролцох, үр дүнтэй суралцах эрх тэгш байдлыг хангах, сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, хүүхэд хөгжил хамгааллын үйлчилгээний хүрээг өргөтгөх, хэрэгжүүлэх арга замыг сайжруулах, сурах орчинд хөрөнгө оруулах шаардлагатай байна.

Тэгш хамруулан сургах боловсрол нь нэг талаас хүн бүрийн онцлог хэрэгцээнд нийцэхүйц, нөгөө талаас тэгш хамруулах сургалтын үйл ажиллагааг явуулах зохицуулалтыг хийх, тухайн хүүхдэд тулгарч буй аливаа

саад тотгорыг арилгахад чиглэнэ. Тухайлбал, боловсрол, сургалтын үр дүн тухайн хүүхдийн ар гэрийн байдал, эцэг эхийн боловсролын түвшин, үндэс угсаа хэл соёл, хөгжлийн бэрхшээл, боловсролын орц, чанар зэрэг тухайн хүүхдээс өөрөөс нь хамаарахгүй хүчин зүйлсийн нөлөөнд байх ёсгүй юм. Нийгэм, эдийн засаг, нөхцөл байдлын олон талт, зарим үед давхацсан хүчин зүйлүүдийг судалж тогтоон бүлгийн хэмжээнд, заримдаа хувь хүүхдэд чиглэсэн тэгш хамруулах арга хэмжээнүүдийг бодлого, төсвийн хувьд авах шаардлагатай байна. Боловсролын тухай хууль тогтоомжуудад сурч боловсрох тэгш боломжоор хангахыг Монгол улсын боловсролын үндсэн зарчим болохыг маш тодорхой тодорхойлсон ч, тэгш эрх, тэгш байдлыг тогтоох, тэгш хамруулалтын үүднээс ялгаварлан гадуурхалтын бүхий л хэлбэртэй тэмцэх чиглэлээр салбар дундын тогтолцооны өөрчлөлтийг хийх зайлшгүй шаардлагатай байна.

## **БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ:**

### **СУРГУУЛИАС ГАДУУРХ ХҮҮХЭД, ӨСВӨР НАСНЫХНЫГ ХЭРХЭН БОЛОВСРОЛД ХАМРУУЛАХ ВЭ?**

Хамгийн эмзэг, гадуурхагдсан хүүхэд, өсвөр үеийнхний боловсролд хамрагдахад, амжилттай суралцахад тулгарч буй саад бэрхшээлийг арилгах бодлогын үндсэн 10 арга хэмжээг танилцуулж байна.



#### **1. Бүх нийтийн сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг өргөжүүлэн бага боловсролд саадгүй шилжин элсэх боломжийг олгох**

Боловсролын гадна орхигддог бүлгийн хүүхдүүдийг насан туршдаа суралцахуйд бэлтгэж танин мэдэхүйн, бие бялдар, нийгэм-сэтгэл зүй зэрэг суурь ур чадваруудыг олгохын тулд бага насны хүүхдийн боловсролд чиглэсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай. Үүний үр дүнд хувийн боловсрол, сургалт руу чиглэсэн өрхийн зардал буурна.

Эрт үеийн суралцахуй нь ерөнхий боловсролын сургуулиа бүрэн дүүрэн төгсөхөд дэмжлэг болох төдийгүй бага, дунд боловсролд хамрагдаж буй хүүхэд, өсвөр үеийнхний сурлагын амжилтыг дээшлүүлдэг. Хамгийн эмзэг, маргинал бүлгийн хүүхдүүдийг хамруулахад төсөв, хөрөнгө оруулалтыг чиглүүлэх нь чухал бөгөөд чухам энэхүү эрт үеийн боловсролыг эх хэлээрээ, чанартай авах нь тэдэнд хамгийн их тустай. Тэд суурь чадваруудад суралцаж, бага сургууль руу саадгүй шилжих нь амьдралыг нь ч өөрчлөх ач холбогдолтой.



## **2. Зохих насандаа сургуульд элсэх, анги дэвших, төгсөхийг дэмжих, шилжилтүүдийг хөнгөвчлөх**

Анги улирах, сургууль завсардах нь тэгш хүртээмж, оролцоог хангах, сургалтын үр дүнг сайжруулах үйл ажиллагаанд маш өндөр өртөг бий болгох сөрөг үр дагавартай. Хүүхэд, өсвөр үеийнхнийг насандаа сургуульд элсэн ороход дэмжих, боловсролын түвшин хоорондын шилжилтийг тогтмол дэмжих, онц байдлын үед боловсролыг хамгаалах үр дүнтэй бодлого, стратеги шаардлагатай байна. Уг зорилгын үүднээс боловсролын бүхий л түвшинд сургалтын хөтөлбөрийн нийцийг ханган багшлахуйг сайжруулж, тэгш хамруулан сургах арга зүйтэй хослуулах нь чухал юм. Мөн Боловсролын мэдээллийн технологийн төв дэх өгөгдлийг сургууль завсардах, эрсдэлт бүлгүүдийг эрт илрүүлэхэд хэрэглэж, урьдчилан сэргийлэх боломжтой юм.



## **3. Суралцахуйд ялангуяа, бүх хүүхэд, өсвөр үеийнхэнд үндсэн ур чадваруудыг эзэмшүүлж, сургалтыг үр дүнтэй явуулахад анхаарах**

Сургалтын таатай орчин нөхцөл, сайн үр дүн нь суралцагчдын оролцоо хийгээд төгсөлтөд эерэг нөлөө үзүүлдэг. Тиймээс боловсролын тогтолцоо нь багшлахуй, суралцахуйн чанарыг тогтвортой сайжруулах шаардлагатай байдаг бөгөөд үр дүнд нь бүх суралцагчид тоо тоолох, бичиг үсгийн ур чадварыг эзэмшиж, заавал эзэмших ерөнхий боловсролыг амжилттай төгсдөг. Энэхүү суурь ур чадварууд дээрээ суурилан хүүхэд, өсвөр насныхан нарийн төвөгтэй мэдлэг, ур чадваруудыг (21р зууны ур чадвар) эзэмших боломжтой. Боловсролын бүхий л үе шатанд сургалтын үр дүн, суралцахуйн үйл явцыг хянаж үнэлэхийн тулд үндэсний хэмжээний үр дүнтэй үнэлгээний тогтолцоо чухал. Нэгдсэн дата мэдээллүүдэд анализ хийснээр суралцахуйд нөлөөлж буй бодлогын цоорхой, үр ашигтай эсэх байдлын талаар тодорхой мэдээллүүдийг өгдөг учир ийм тогтолцоонд хөрөнгө оруулах нь урт хугацаандаа зардал багатай байна.

Мөн багшлахуй ба суралцахуйг сайжруулах зорилгоор анги танхимд суурилсан явцын үнэлгээг тогтмол хийхэд багш нарыг сургаж, дэмжлэг үзүүлснээр хүүхдүүд анги улирах, сургууль завсардахаас сэргийлж чадна. Үүний гол суурь нь сургуулийн түвшний үр дүнтэй, тэгш хамруулсан сургалтын орчныг бүрдүүлэх зорилготой сургуулийн захирал, сургалтын менежерийн сургах зүйн манлайлал, дэмжлэг юм.





#### **4. Уян хатан стратеги, арга зам бүхий жинхэнэ тэгш хамруулсан боловсролын тогтолцоог хөгжүүлэх**

Боловсролын тогтолцоо нь суралцагчдад тулгарч буй олон саад бэрхшээл, сорилтуудыг шийдвэрлэж илүү тэгш хамруулсан болох шаардлагатай. Боловсролын алсын хараатай стратеги, улс төрийн хүсэл зориг, бодит төлөвлөлт, төсөвлөлт, тодорхой стратегиудыг хэрэгжүүлснээр тэгш хамруулсан боловсрол хэрэгжинэ. Тухайлбал, эх хэл дээр суурилсан болон олон хэлний эрт үеийн бичиг үсгийн боловсролын хөтөлбөрүүд, жендэрийн мэдрэмжтэй суралцахуйн болон багшлахуйн хэрэглэгдэхүүн, ядуу өрхийн хүүхдэд чиглэсэн сургалтын тэтгэлэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулагдсан суралцахуйн түгээмэл загвартай технологийн дэмжлэгүүд зэргийг онцолж болно. Түүнчлэн боловсролын тогтолцоо нь эрчимжүүлсэн суралцахуй, уян хатан загварууд, дүйцүүлэх хөтөлбөрүүд зэрэг албан бус боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шинэлэг санаануудыг нэвтрүүлэх, магадлан итгэмжлэх болон гэрчилгээжүүлэх боломжит замуудтэй уян хатан, нөхцөл байдалд тохируулан өөрчилж болохуйц болох ёстой. Ийм дүйцүүлэх хүрээ нь хүүхэд, өсвөр үеийнхнийг албан болон албан бус боловсролоор дамжин суралцахад дэмжлэг болох ба боловсролын боломжийн хувьд эрх тэгш байдлыг бий болгодог.



#### **5. Сургуулийн эгэх хариуцлагын төвлөрсөн бус байдлыг дэмжих ба орон нутгийн түвшний үйлдэл, шийдэлд сургуулийн цогц дэмжлэгийг үзүүлэх**

Орон нутаг бүрт боловсролын үйлчилгээг сайжруулах гол түлхүүр нь шийдвэр гаргах эрх мэдэл, хөрөнгө нөөц, үүнтэй холбогдох үүрэг хариуцлагыг багтаасан сургуульд суурилсан менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэх явдал юм.

Сайтар удирдсан төвлөрлийг сааруулах үйл явц сургуулийн бие даасан байдлыг нэмэгдүүлж, сургуулийн хамт олон болон оролцогч талуудыг эрх мэдэлжүүлэн, орон нутгийн эрэлт хэрэгцээнд хариу үйлдэл үзүүлэх байдлыг урамшуулан дэмжих замаар боловсрол дахь оролцоо, сургалтын үр дүнг сайжруулах боломжтой. Нийгэм, эдийн засгийн таатай нөхцөл бололцоогүй бүс нутагт байгаа сургуулиуд төрөл бүрийн сорилтыг даван туулах дотоод чадавх, нөөц хомс байдаг тул тэднийг орон нутгийн болон төрийн дэмжлэг, нөөцөөр хангахад нэн тэргүүнд анхаарах ёстой. Бодит үр дүн гаргахын тулд тэдгээр сургуулиудад төрөл бүрийн дэмжлэгийг (жишээ нь: дэд бүтэц, сургалтын хэрэглэгдэхүүн, багш, санхүүжилт гэх мэт) салангид биш нэг дор, зохион байгуулалттай үзүүлэх шаардлагатай. Эдгээр сургуулиудад сургуулийн өөрийн үнэлгээнд суурилсан сайжруулах, сургуулийн удирдлагын

манлайллыг сайжруулах, олон нийтийн утга учиртай оролцоог дэмжихийн тулд мэргэжлийн хяналт, үзлэг (алдааг илрүүлэх шалгалт бус) чанарын хяналт, баталгаажуулалтыг тогтмол, сайжруулах зорилгоор хийж байх нь тус болно.



## **6. Ур чадварын зөв хослол бүхий багш, сургуулийн удирдлагуудыг ажилд татан авч, хөгжүүлж, ажилд нь тогтоох ба эрх тэгш хуваарилан ажиллуулах**

Сургуулийн боловсон хүчний чадавх нь хүүхэд, өсвөр үеийнхний суралцахуйн хэрэгцээг эрх тэгш хангах амжилттай бодлогыг хэрэгжүүлэх үндэс суурь болдог. Өөрөөр хэлбэл, сайн бэлтгэгдсэн, мэргэшсэн, урам зоригтой багш нар, сургуулийн удирдлагууд нь нийгэм-эдийн засгийн таатай нөхцөл бололцоогүй, сурлагын амжилтын хувьд тааруу сургуулиудыг эрх тэгш байдал, чанарыг дэмждэг, сайн ажилладаг, үр дүнтэй сургууль болгон хувирган өөрчлөх гол хүч юм. Тэдэн рүү чиглэсэн бодлого нь багш бэлтгэх чанартай боловсролын болон ажлын байран дээрээ тасралтгүй мэргэжил дээшлүүлэх боломжоор хангагдсан байхад чиглэх хэрэгтэй. Нийгэм, эдийн засгийн таатай нөхцөл бололцоогүй орон нутагт байгаа сургуулиудад ур чадвартай багшлах боловсон хүчнийг татах, тогтоохын тулд боловсролын тогтолцоо нь зохих санхүүгийн болон албан тушаал ахих урамшуулал, түүнчлэн зөвлөн туслах, дасгалжуулах дэмжлэг зэргийг багтаасан ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлж өгөх хэрэгтэй. Боловсролын салбарт ажиллах хүчнийг татах, удирдахдаа түр зуурын, алт нэг талд давуу байдал олгосон, хот сууринг чухалчилсан бодлогоос илүүтэй боловсролын өгөгдөл, хэрэгцээнд суурилсан бодлого хэрэгтэй.



## **7. Эрх тэгш байдлыг үр дүнтэй хангахын тулд мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, ашиглах**

Боловсролын тэгш бус байдлыг арилгах хүчин чармайлтын гол цөм нь дата, өгөгдөл юм. Тиймээс үндэсний статистикийн тогтолцоог, ялангуяа боловсролын удирдлага-мэдээллийн системийг бэхжүүлэх шаардлагатай бөгөөд эмзэг бүлгийн хүн амтай (жишээ нь үндэс угсаа, хөгжлийн бэрхшээл, хэл гэх мэт) хамааралтай хувьсагчтай мэдээллийг цаг алдалгүй, холбоо хамаарлыг харуулан, найдвартай тоо мэдээлэл гаргах шаардлагатай байна. Тогтвортой хөгжлийн зорилт 4 хэрэгжилтийг хангахын тулд боловсролын хяналт-шинжилгээг олон төрлийн мэдээллийн эх сурвалжаас (жишээ нь: захиргааны тоо мэдээлэл, өрхийн судалгаа, сурлагын амжилтын үнэлгээ, санхүү төсвийн мэдээлэл зэрэг) мэдээллийг нэгтгэх ёстой тул Боловсролын ямаас гадна байгаа дотоод болон гадаад төрөл бүрийн мэдээлэл боловсруулагч/бүртгэгчтэй (жишээ нь, иргэний бүртгэл, эрүүл

мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөр зэрэг) нягт холбоо тогтоон ажиллах ёстой.



## **8. Засгийн Газар улсын төсөвт боловсролын салбарыг чухалчилж, ухаалаг, үр ашигтай хөрөнгө оруулалтыг хийх**

Ази-Номхон далайн бүс нутгийн улс орнуудын Засгийн газруудад өгч буй зөвлөмжөөр боловсролын зардлыг нийт төсвийн 15-20 хувь, ДНБ-ий 4-6 хувьтай тэнцүүлэх олон улсын бенчмаркыг биелүүлэх нь чухал байна. Засгийн газрууд боловсролын зардлыг нэн тэргүүнд тавьж, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролд төсвөөс хуваарилах зардлыг нэмэх шаардлагатай байсаар байна.

Төрийн санхүүжилтийн тогтолцоог боловсролын салбарт бэхжүүлэх нь нөөцийг эрх тэгш хуваарилах, тэргүүлэх чиглэлд болон хүн амын тодорхой бүлэгт чиглэсэн хөрөнгө оруулалт авчрах (жишээлбэл, сургуульд чиглэсэн буцалтгүй тусламж, тэтгэлэг, амьжиргааны зардал, багшлах нөөц рүү чиглэсэн бодлого болон бусад дэмжлэгийн тогтолцоонууд) хийх замаар хүүхдүүдэд, ялангуяа хамгийн эмзэг, нийгэм-эдийн засгийн бололцоо муутай суралцагчдад сайн үр дүн авчирдаг.



## **9. Маргинал бүлгүүдэд чиглэн ажилладаг оролцогч талуудын түншлэл, зохицуулалтыг сайжруулах**

Ихэнх улс оронд үндэсний болон орон нутгийн түвшинд бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд нь нөлөөлөх маргинал бүлгүүдийн дуу хоолой, оролцоо хэрэгтэй байдаг. Сургуулийн гадна байгаа хүүхэд, өсвөр үеийнхний эргэн тойронд тулгарч буй ээдрээтэй, асар том сорилтуудыг шийдвэрлэхийн тулд янз бүрийн оролцогч талууд хүчээ нэгтгэж, өөрсдийн хүч чадал, нөөц бололцоогоо дайчлахыг шаарддаг.

Үндэсний хэмжээнд үр дүнтэй бодлогын нөлөөлөл, харилцаа холбоо нь олон талт оролцогч талууд буюу иргэний нийгэм, шашны удирдагчид, бизнес/компаниуд, залуучуудын бүлгүүд гэх мэт боловсролд оролцогчдод маргинал бүлгийнхний боловсролыг дэмжих зорилгоор нэгдэхийг дэмжих үндэс суурь юм. Шилжин суурьшигч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд, алслагдсан газар амьдардаг хүүхдүүд зэрэгт чиглэсэн чанар муутай, хувийн боловсролын үйлчилгээний эсрэг бодлогын нөлөөлөл хийхэд боловсролын оролцогч талуудын үйл ажиллагааны зохицуулалт илүү хүчтэй болох ёстой.



## **10. Сургууль, түүний эргэн тойрон дахь ядуурал, хүчирхийлэлтэй холбоотой саад бэрхшээлийг даван туулахын тулд салбар дундын хандлага-арга зүй, арга хэмжээг дэмжих**

Сургууль завсардсан болон сургуулийн гадна байгаа хүүхдүүдийн ялгаатай хэрэгцээ, тэдэнд тулгарч буй сорилт, бэрхшээл нь олон янз, жишээлбэл: эрүүл мэнд, хоол тэжээл, ус, ариун цэврийн байгууламж, хүүхэд хамгаалал, нийгмийн хамгаалал гэх мэт. Иймд жендэрийн мэдрэмжтэй цогц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр шаардлагатай. Жишээлбэл, ядууралд буй гэр бүлүүдийн хүүхдийн хөдөлмөрөөс хамааралтай байдлыг бууруулах, тэдгээр хүүхдүүдийг сургуульд сургах, тогтвортой суралцахад нь дэмжлэг үзүүлэх салбар дундын шийдлийг шаарддаг. Улмаар нийгмийн хамгааллын зохих механизмууд, тухайлбал, хичээлийн ирц сайн байх, сурлагын амжилтад суурилсан мөнгөн тэтгэлэг, амьжиргааны зардлыг шийддэг тэтгэмж зэрэг нь гэр бүлийн ядуурлаас үл хамааран сургуульд элсэх, хамрагдах, үргэлжлүүлэн суралцах үйл явцад үзүүлэх нөлөөллийг бууруулахад эерэг нөлөө үзүүлдэг. Мөн сургууль, түүний эргэн тойрон дахь хүчирхийлэлтэй холбоотой саад бэрхшээлүүд, тухайлбал жендэрт суурилсан хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлт, сургууль дээрх бие махбодын шийтгэл зэргээс хамгаалсан хүүхдийн сайн сайхан байдалд анхаарсан, үр дүнтэй, аюулгүй суралцах боломжийг хангахад чиглэсэн бодлогын арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай.



## “БҮХ НИЙТ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ!” ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮНДЭСНИЙ ЭВСЛИЙН

### ТУНХАГ

Боловсрол нь хүн бүрийн өдөр тутмын амьдралд, насан турш нөлөөлөх үндсэн эрх, хүний хөгжлийн түлхүүр бөгөөд иргэн бүрт чанартай боловсрол олгох нь төрийн хүлээх гол үүрэг хариуцлага гэдэгт итгэн;

Өнөөгийн тогтолцоонд боловсролыг явцуу тодорхойлдог, хүн бүрийн ялгаатай байдлыг харгалздаггүй, ялгаварлан гадуурхдаг, хангалттай санхүүжилт олгодоггүй зэргээс шалтгаалан бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцад цогц хандлага дутагдаж; боловсролын тогтолцооны үр өгөөж нь хувь хүний хүсэл тэмүүлэл, нийгмийн эрэлт хэрэгцээнээс асар зөрүүтэй байсаар ирсний улмаас үнэ цэнэтэй амьдарч, амьдралын чанараа дээшлүүлэх боломж олгохгүй байгаад сэтгэл зовнин;

Энэ нь эрх мэдлийн шударга бус бүтцийг бий болгож, тэгш бус байдлыг хадгалж үлдэх арга зам болж байгааг эсэргүүцэн;

Боловсролын чанар, хүртээмж, хариуцлагатай байдлын төлөө хүчээ нэгтгэн ажиллаж, энэ үйл явцад хувь хүн, иргэний нийгмийн байгууллага, бүлгүүдийг өргөнөөр татан



оролцуулж, өргөн суурьтай, зохион байгуулалттай, хүчтэй хөдөлгөөн бий болгохыг чухалчлан;

Энэ үйл явцад нийгмийн бүх бүлэг, ялангуяа эрх мэдлийн цөөнхийн оролцоог хангахыг онцлон;

Иргэд, бүлгүүдийн мэдлэг, чадварыг хөгжүүлж, тулгарсан асуудлаа гаргаж ирэх, шийдлийг шаардах, хариуцлага тооцох чадавхтай болоход нь дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэн;

Боловсролын тогтолцоог хүний мэдэх, бүтээх, хүний ёсоор хамтран амьдарч, нэр төртэйгээр оршиход суралцахуйц, хувь хүний потенциал, чадвар, чадавхыг нээж, эерэг зан үйл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн, хүмүүнлэг, ардчилсан, хүн бүрийн эрхийг хангасан, тэгш хүртээмжтэй болгон өөрчлөхийг эрхэмлэн;

Хүүхэд, эцэг эх, багш, орон нутгийн бүлгүүд болон үндэсний, хэлний, соёлын, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, орлого багатай иргэд зэрэг дуу хоолойгоо хүргэж, шийдвэр гаргахад оролцож чадахгүй байгаа бүлгүүдийг эрх мэдэлжүүлэх зорилгоор боловсролын тогтолцоо, бодлогод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадавхыг бүрдүүлэх, нөлөөлөх ур чадвараа дээшлүүлэх шаардлагыг ухамсарлан;

Хүний эрх, жендэрийн тэгш эрх, үл ялгаварлан гадуурхах, хүчирхийллээс ангид, хүлээцтэй байх, нээлттэй, ил тод, хариуцлагатай байх зарчмыг баримтлан;

Монгол улсад боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийг хянах, хариуцлага шаардах, бодлогод нөлөөлөх үндэсний кампанит ажил зохион байгуулах зорилгоор эвсэн нэгдсэнээ тунхаглаж байна.

**2010 оны 9 сарын 3**



